

# ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ МЭДЭЭ

Гадаад зах зээл

2023.11.10



## ОНЦЛОХ МЭДЭЭ :

Баярын улирал хэрэглэгчдэд баяр хөөр, айдсын алийг нь авчрах вэ?

## Өнгөрсөн 7 хоногийн мэдээнээс онцлох зүйлс:

- Өрхийн хадгаламжийн орлогод эзлэх хувь доод түвшинд хүртлээ буурчээ.
- АНУ 2023 оны III улирлын байдлаар зээлийн картын үлдэгдэл 1 их наяд доллароос давсан байна.
- АНУ-д зээлийн карт ба автомашины зээл төлөлтийн хугацаа хэтрэлт нэмэгджээ.
- Банкны шалгуураа өндөр хэвээр барьж байгаа нь иргэдэд болон бизнес эрхлэгчдэд зээл авахад хүндрэл учруулж байна.

АНУ-ын эдийн засаг 2023 оны эхний гурван улиралд үнэхээр тогтвортой байсан. Үнэн хэрэгтээ III улирлын ДНБ-ий 4.9%-ийн жилийн өсөлт нь 2021 оноос хойших хамгийн өндөр өсөлт байсан бөгөөд АНУ-ын өсөлтийн дундаж 1.5%-2.0%-иас хавьгүй дээгүүр байв. Эдийн засгийн энэхүү өсөлт нь хувийн хэрэглээнээс шалтгаалсан ба энэ жил тус үзүүлэлт мөн сайн өссөн билээ. Бидний мэдэж байгаагаар АНУ-ын эдийн засаг хэрэглэгчид ба тэдний зарцуулалтаас ихээхэн хамаардаг (хэрэглээний зарцуулалт АНУ-ын ДНБ-ий 70 орчим хувийг эзэлдэг).

Жилийн эцэс буюу баярын худалдааны улирал ирж байгаа энэ үед хэрэглэгчид өмнөх шигээ зарлага гаргаж чадах уу гэсэн асуулт гарч ирж байна. Цаашид зарцуулалт бага зэрэг удааширч магадгүйг батлах гурван хүчин зүйлийг бид доор жагсаав:

### 1. Хадгаламжийн хувь буурсан

Царт тахлын үед бий болсон нэг онцлог зүйл бол өрхүүд их хэмжээний бэлэн мөнгөтэй болсон явдал байв. Сан Францискогийн ХНС-ийн мэдээлснээр өрхүүд 2021 онд ойролцоогоор 2.1 их наяд долларын илүү хуримтлал бий болгосон байна. Гэсэн хэдий ч сүүлийн хоёр жилийн хугацаанд хүмүүс эдгээр хадгаламжийнхаа ихэнх хувийг бараа, үйлчилгээнд зарцуулсан тул нийт хадгаламж дууссан байж магадгүй.

Доорх графикаас харахад өрхийн хуримтлалын түвшин тахлын дараах хамгийн доод түвшинд хүрч буурсан нь олон хэрэглэгчид хэмнэхийн оронд ердийнхөөсөө хамаагүй их мөнгө зарцуулж байгааг харуулж байна. Энэ нь эдийн засгийг сэргээх үеэр зардал өсөж, хуримтлал буурдагтай холбоотой юм. Инфляц өндөр хэвээр үлдэхэд бага орлоготой өрхүүд бараа, үйлчилгээний аль алинд нь илүү их мөнгө зарцуулахын тулд хуримтлал багасаж буй илүү ихээр мэдэрдэг. Хэрэглэгчид зардлаа мэдэгдэхүйц бууруулж байгаа нь хараахан мэдэгдэхгүй байгаа хэдий ч хадгаламжийн хувь хэмжээ тахлын өмнөх үеийн дундаж 6%-д (одоогийн байдлаар 3.4% байгаа) буцаж ирэх юм бол хэрэглээ нь аяндаа багасаж магадгүй.

**График 1. Өрхийн хадгаламжийн хувь хэмжээ бараг мөчлөгийн доод түвшинд хүртэл буурчээ.**



## 2. Зээлийн картын үлдэгдэл нэмэгдэхээс гадна зээл төлөлтийн хугацаа хэтрэлт нэмэгдэж байна


Хувийн хадгаламжийн хувь буурахын хэрээр хэрэглэгчид зээлийн картын нийт өр нэмэгдэж байна. АНУ-ын зээлийн картын нийт өр 2023 оны III улирлын байдлаар нэг их наяд ам.доллар давсан нь түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт болов.

**График 2. АНУ 2023 оны III улирлын байдлаар зээлийн картын үлдэгдэл 1 их наяд доллароос давсан байна.**



Өрхийн зээлийн картын үлдэгдэл өсөхийн хэрээр зээлийн карт болон автомашины зээлийн төлөлтийн хугацаа хэтрэлт ихэсдэгийг доорх графикаас харж болно. Тус үзүүлэлт өмнөх хямралын үеийнх шиг хэмжээнд хүртэл өсөөгүй байгаа ч ажиглаж байх хэрэгтэй. Өрхүүд өрөө төлөхийн тулд ирэх саруудад зарцуулалтын төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулах шаардлагатай тулгарч магадгүй бөгөөд энэ нь нийт хэрэглээ багасна гэсэн үг юм.

**График 3. АНУ-д зээлийн карт ба автомашины зээл төлөлтийн хугацаа хэтрэлт нэмэгджээ.**




### 3. Банкны зээлийн шалгуур өндөр хэвээр

Хэрэглэгчид өндөр хүүтэй, банкны зээлийн хатуу стандарттай тулгарсаар байгаа нь нууц биш. Өнгөрсөн долоо хоногт ХНС-аас зээлийн ахлах ажилтнуудын улирал тутам хийсэн судалгаанд банкууд иргэдэд болон бизнес эрхлэгчдэд өндөр шаардлага тавьсаар байгааг дурджээ. Банкнууд зээлийн өндөр шалгуурыг барьсаар байгаа тул иргэд болон жижиг, дунд, том бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн стандартыг чангатгасан.

Зээлийн шаардлага хангаагүй иргэд ба жижиг бизнесүүд төлөвлөгөөт нэмэлт худалдан авалт хийж, төслөө хэрэгжүүлж чадахгүй тул энэ нь эргээд хэрэглээнд дарамт болж байгаа юм. Доорх графикаас харахад банкны зээлийн шалгуур өмнөх эдийн засгийн хямралын үед ажиглагдсан шиг нэмэгдсэнийг харж болно.

**График 4. Банкны шалгуураа өндөр хэвээр барьж байгаа нь иргэдэд болон бизнес эрхлэгчдэд зээл авахад хүндрэл учруулж байна.**

**АНУ-ын ахлах зээлийн мэргэжилтнүүдийн судалгаа, нийт чангарсан %, жижиг байгууллагууд**



Түүнээс гадна хэрэглэгчдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж болзошгүй улс төр, геополитикийн эрсдэлүүд байсаар байгааг дурдах хэрэгтэй. АНУ-ын засгийн газрын үйл ажиллагааг зогсоох эцсийн хугацаа нь 11 сарын 17 боловч танхимын дарга байгаа тул тогтоолыг үргэлжлүүлэн сунгах магадлал өндөр. Гэсэн хэдий ч энэхүү тодорхойгүй байдал нь хэрэглэгчдийн сэтгэл санаанд нөлөөж хэрэглээнд дарамт учруулан, хэрвээ засгийн газар дахиад хаагдвал эдгээр хүмүүст хамгийн ихээр нөлөөлөхөөр харагдаж байна.

### **Буурсаар байгаа хэрэглээнд сайн тал бий юу? Инфляц ба ХНС-ийн хувьд харвал**

Ерөнхийдөө, хэрэглээ цаашид удаашрах төлөвтэй байгаа ч жилийн эхэн үед өндөр байсан ба бүтэн жилийн турш бага багаар буурч байсныг санах хэрэгтэй. Хэрэглээний боломжит сулрал нь эдийн засгийн өсөлтийг бууруулж болзошгүй ч эерэг талууд бас бий, тухайлбал инфляц болон ХНС-ийн хүүгийн өсөлтийг хэвээр үлдээж магадгүй юм.

Хэрэглээ болон АНУ-ын эдийн засаг муудахын хэрээр компаниуд эрэлт багасахтай дасан зохицохын тулд үнээ бууруулж магадгүй юм. Ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлт илүү тэнцвэртэй байх тусам цалин бага зэрэг өсөх магадлалтай. Энэ хэвээрээ үргэлжилбэл инфляцыг бага түвшинд байлгаж, ХНС цаашид бодлогын хүүгээ дахин өсгөх шаардлагагүй болсноор санхүүгийн зах зээл, хөрөнгө оруулагчдын аль алинд нь сайн талтай.

Ирэх саруудад хэрэглэгчдийн эрэлт бага зэрэг сулрах төлөвтэй байгаа ч удаан үргэлжилнэ гэж бодохгүй байна. Хэрэв инфляц тогтвортой хэвээр үлдэж ХНС шийдвэрээ харзсан хэвээр байвал ирээдүйд хэрэглээ сэргэж магадгүй.

### **Хэрэглээ ба эдийн засгийн удаашралын зах зээлд үзүүлэх нөлөө**

Хөрөнгийн зах зээлийн түүхээс харахад зах зээл ирээдүйд тулгуурласан чиг хандлагатай байдаг тул эдийн засгийн мөчлөг дуусахаас сэргэж эхэлдэг. Эдийн засгийн удаашрах магадлалтай бөгөөд хэрвээ хэрэглээ багасаад эхэлбэл зах удахгүй сэргэнэ гэж бодож болно.

Тиймээс бид ирэх сарууд дах тогтворгүй байдлыг боломжийн үнээр сайн хөрөнгө оруулалтыг төрөлжүүлэн, тэнцвэржүүлж, бий болгох боломж гэж харах хэрэгтэй. Инфляц буурч, ХНС шийдвэрээ түр азнаж, эцэст нь хүүгээ бууруулж, хямралын дараа хэрэглээ дахин нэмэгдэж, энэ гурван макро эдийн засгийн чухал үйл явдал тохиосноор хувьцаа, бондын аль алинд нь боломж гарч ирнэ гэж бид харж байна.

## **САНАМЖ**

Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-иас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Илэрхийлсэн үзэл бодол нь зөвхөн шинжээчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд зах зээл болон бусад хүчин зүйлсийн нөлөөллөөр өөрчлөгдөх боломжтой юм. Бүх мэдээ, мэдээллүүд нь үүнд Ард Секюритиз ҮЦК-ийн эх сурвалж болгосон буюу гаргасан мэдээлэл үнэн бодит гэж үзсэн эх сурвалжаас авсан боловч нарийвчлал нь баталгаажуулаагүй болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!